



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэбулган сумын Хүүхдийн 13 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2022/162/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaa.T@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Нэргүйбаатар Утас: 70332860 Цахим хаяг: Nerguibaatar.d@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Цог-Эрдэнэ Утас: 99210906 Цахим хаяг: Tsogerdene.g@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1. Аудитын дүгнэлт

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	13
3.4 Материаллаг байдал .....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	15
3.8 Аудитын гол асуудал .....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт .....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	17
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар

## 1. АУДИТЫН ДҮГНЭЛТ



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг  
Утас/Факс: 976-70333141  
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ХҮҮХДИЙН 13  
ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Г.МИНЖМАА ТАНАА

2022.02.25 № 128  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэбулган сумын Хүүхдийн 13 дугаар Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэбулган сумын Хүүхдийн 13 дугаар Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхгүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	31,569,969.61	44,688,278.61
2	БАРАА МАТЕРИАЛ	31,569,969.61	44,688,278.61
3	Хангамжийн материал	31,569,969.61	44,688,278.61
4	Аж ахуйн материал	31,569,969.61	44,195,537.61
5	Хүнсний материал		492,741
6	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	861,321,118.38	853,635,273.08
7	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	861,321,118.38	853,635,273.08
8	Биет хөрөнгө	857,962,785.24	850,583,773.08
9	Барилга, байгууламж, орон сууц	861,230,096	861,230,096
10	Хуримтлагдсан элэгдэл	-28,707,669.84	-43,061,504.76
11	Машин тоног төхөөрөмж(компьютер)	38,224,077.5	32,712,009.5
12	Хуримтлагдсан элэгдэл	-22,239,124.49	-8,534,332.1
13	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,286,201.4	13,286,201.4
14	Хуримтлагдсан элэгдэл	-3,830,795.33	-5,048,696.96
15	Биет бус хөрөнгө	3,358,333.14	3,051,500
16	Програм хангамж	2,417,500	1,537,500
17	Хуримтлагдсан элэгдэл	-1,203,166.86	-630,000
18	Бусад биет бус хөрөнгө	2,144,000	2,144,000
19	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	892,891,087.99	898,323,551.69
20	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	892,891,087.99	898,323,551.69
21	Засгийн газрын хувь оролцоо	892,891,087.99	898,323,551.69
22	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,144,000	2,144,000
23	Хуримтлагдсан үр дүн	662,294,769.59	667,727,233.29
24	Өмнөх үеийн үр дүн	670,421,649.77	662,294,769.59
25	Тайлант үеийн үр дүн	-8,126,880.18	5,432,463.7
26	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	228,452,318.4	228,452,318.4
27	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	892,891,087.99	898,323,551.69

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	288,535,996.25	314,168,101
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,848,296.25	18,889,701
3	Нийтлэг татварын бус орлого	9,848,296.25	18,889,701
4	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,848,296.25	
5	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,848,296.25	
6	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		9,961,633
7	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		8,928,068
8	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	278,687,700	295,278,400
9	Улсын төвлөрсөн төсвөөс	252,763,200	268,132,800
10	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	252,763,200	268,132,800
11	Нэмэлт санхүүжилтийн орлого	105,000	191,900
12	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		191,900
13	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	105,000	
14	Орон нутгийн төсвөөс санхүүжих	25,819,500	26,953,700
15	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	25,819,500	26,953,700
16	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	296,662,876.43	308,735,637.3
17	УРСГАЛ ЗАРДАЛ	296,662,876.43	308,735,637.3
18	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	290,474,166.43	295,520,116.3
19	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	202,088,835	206,007,115
20	Үндсэн цалин	159,377,943	156,525,853
21	Нэмэгдэл	24,097,682	31,543,397
22	Урамшуулал	18,613,210	17,937,865
23	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,326,165	27,361,471
24	Тэтгэврийн даатгал	16,842,295.82	19,330,957.31
25	Тэтгэмжийн даатгал	2,246,319.19	2,039,365.54
26	ҮОМШӨ-ний даатгал	1,687,501.15	1,631,491.6
27	Ажилгүйдлийн даатгал	416,304.64	394,725.63
28	Эрүүл мэндийн даатгал	4,133,744.2	3,964,930.92
29	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,987,035	24,932,380
30	Гэрэл, цахилгаан	1,000,929	3,258,930
31	Түлш, халаалт	18,996,500	20,232,000
32	Цэвэр, бохир ус	989,606	1,441,450
33	Хангамж, бараа материалын зардал	3,115,840.92	1,374,280
34	Бичиг хэрэг	555,800	163,280
35	Тээвэр, шатахуун	122,000	150,000
36	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	714,500	451,900
37	Ном, хэвлэл	232,920	24,000
38	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		41,900
39	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	916,130	543,200
40	Бараа материал акталсны зардал	574,490.92	
41	Нормативт зардал	16,333,774	14,307,672
42	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,034,200	4,236,400
43	Хоол, хүнс	15,299,574	10,071,272
44	Эд хогшил, урсгал засварын зардал	420,360	613,500
45	Урсгал засвар	420,360	613,500
46	Томилолт, зочны зардал		78,000
47	Дотоод албан томилолт		78,000
48	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	543,400	285,500

49	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	293,400	185,500
50	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000	100,000
51	Бараа үйлчилгээний бусад зардал	21,658,756.51	20,560,198.3
52	Бараа үйлчилгээний бусад зардал	121,450	
53	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	858,000	712,720
54	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,679,306.51	19,847,478.3
55	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,188,710	13,215,521
56	Бусад урсгал шилжүүлэг	125,500	150,000
57	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	125,500	150,000
58	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,802,465	1,390,820
59	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,802,465	1,390,820
60	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,260,745	11,674,701
61	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,260,745	11,674,701
62	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-8,126,880.18	5,432,463.7
63	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-8,126,880.18	5,432,463.7

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,144,000	228,452,318.4	670,421,649.77	901,017,968.17
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,144,000	228,452,318.4	670,421,649.77	901,017,968.17
3	Тайлант үеийн үр дүн			-8,126,880.18	-8,126,880.18
4	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,144,000	228,452,318.4	662,294,769.59	892,891,087.99
5	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,144,000	228,452,318.4	662,294,769.59	892,891,087.99
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,144,000	228,452,318.4	662,294,769.59	892,891,087.99
7	Тайлант үеийн үр дүн			5,432,463.7	5,432,463.7
8	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,144,000	228,452,318.4	667,727,233.29	898,323,551.69

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	өмнөх он	тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	278,687,700	295,278,400
2	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	278,687,700	295,278,400
3	Улсын төвлөрсөн төсвөөс	252,763,200	268,132,800
4	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	252,763,200	268,132,800
5	Нэмэлт санхүүжилтийн орлого	105,000	191,900
6	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		191,900
7	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	105,000	
8	Орон нутгийн төсвөөс санхүүжих	25,819,500	26,953,700
9	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	25,819,500	26,953,700
10	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	276,137,900	293,078,400
11	УРСГАЛ ЗАРДАЛ	276,137,900	293,078,400
12	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	269,949,190	279,862,879
13	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	200,461,700	205,995,291
14	Үндсэн цалин	151,270,794	152,721,559
15	Нэмэгдэл	31,826,541	34,559,777
16	Урамшуулал	17,364,365	18,713,955
17	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,953,300	27,373,295
18	Тэтгэврийн даатгал	18,670,900	19,342,781.31
19	Тэтгэмжийн даатгал	2,070,600	2,039,365.54
20	ҮОМШӨ-ний даатгал	1,656,500	1,631,491.6
21	Ажилгүйдлийн даатгал	414,100	394,725.63
22	Эрүүл мэндийн даатгал	4,141,200	3,964,930.92
23	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,047,035	24,932,380
24	Гэрэл, цахилгаан	1,000,929	3,258,930
25	Түлш, халаалт	18,996,500	20,232,000
26	Цэвэр, бохир ус	1,049,606	1,441,450
27	Хангамж, бараа материалын зардал	2,696,500	1,561,900
28	Бичиг хэрэг	660,500	365,000
29	Тээвэр, шатахуун	120,000	150,000
30	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	764,900	453,300
31	Ном, хэвлэл	234,900	24,000
32	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		62,900
33	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	916,200	506,700
34	Нормативт зардал	15,951,455	16,918,013
35	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,032,100	5,927,800
36	Хоол, хүнс	14,610,855	10,564,013
37	Нормын хувцас, зөөлөн эдлэл	308,500	426,200
38	Эд хогшил, урсгал засварын зардал	820,100	630,500
39	Багаж, техник, хэрэгсэл		
40	Урсгал засвар	820,100	630,500
41	Томилолт, зочны зардал		78,000
42	Дотоод албан томилолт		78,000
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	476,200	1,364,100
44	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	276,200	1,264,100
45	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000	100,000
46	Бараа үйлчилгээний бусад зардал	1,542,900	1,009,400
47	Бараа үйлчилгээний бусад зардал	139,300	
48	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,403,600	1,009,400

49	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,188,710	13,215,521
50	Бусад урсгал шилжүүлэг	125,500	150,000
51	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	125,500	150,000
52	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,802,465	1,390,820
53	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,802,465	1,390,820
54	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,260,745	11,674,701
55	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,260,745	11,674,701
56	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,549,800	2,200,000
57	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,549,800	2,200,000
58	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,549,800	2,200,000
59	Дотоод эх үүсвэрээр	2,549,800	2,200,000
60	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,549,800	2,200,000
61	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-2,549,800	-2,200,000
62	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		
63	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
64	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	295,086,500	282,020,979	13,065,521.00	95.57
2	УРСГАЛ ЗАРДАЛ	295,086,500	282,020,979	13,065,521.00	95.57
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	294,936,500	281,870,979	13,065,521.00	95.57
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	208,250,000	205,995,291	2,254,709.00	98.92
5	Үндсэн цалин	158,960,400	152,721,559	6,238,841.00	96.08
6	Нэмэгдэл	29,957,900	34,559,777	(4,601,877.00)	115.36
7	Урамшуулал	19,331,700	18,713,955	617,745.00	96.80
8	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,814,800	27,373,295	441,505.00	98.41
9	Тэтгэврийн даатгал	19,704,800	19,342,781.31	362,018.69	98.16
10	Тэтгэмжийн даатгал	2,027,500	2,039,365.54	(11,865.54)	100.59
11	ҮОМШӨ-ний даатгал	1,622,000	1,631,491.60	(9,491.60)	100.59
12	Ажилгүйдлийн даатгал	405,500	394,725.63	10,774.37	97.34
13	Эрүүл мэндийн даатгал	4,055,000	3,964,930.92	90,069.08	97.78
14	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,323,200	24,932,380	1,390,820.00	94.72
15	Гэрэл, цахилгаан	2,463,500	3,258,930	(795,430.00)	132.29
16	Түлш, халаалт	19,459,700	20,232,000	(772,300.00)	103.97
17	Цэвэр, бохир ус	4,400,000	1,441,450	2,958,550.00	32.76
18	Хангамж, бараа материалын зардал	1,421,900	1,421,900	-	100.00
19	Бичиг хэрэг	76,300	225,000	(148,700.00)	294.89
20	Тээвэр, шатахуун	150,000	150,000	-	100.00
21	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	492,400	453,300	39,100.00	92.06
22	Ном, хэвлэл	48,200	24,000	24,200.00	49.79
23	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	167,400	62,900	104,500.00	37.57
24	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	487,600	506,700	(19,100.00)	103.92
25	Нормативт зардал	25,844,600	16,866,113	8,978,487.00	65.26
26	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,875,900	5,875,900	-	100.00
27	Хоол, хүнс	19,542,500	10,564,013	8,978,487.00	54.06
28	Нормын хувцас, зөөлөн эдлэл	426,200	426,200	-	100.00
29	Эд хогшил, урсгал засварын зардал	2,830,500	2,830,500	-	100.00
30	Багаж, техник, хэрэгсэл	2,200,000	2,200,000	-	100.00
31	Урсгал засвар	630,500	630,500	-	100.00
32	Томилолт, зочны зардал	78,000	78,000	-	100.00

**Эрдэнэбулган сумын Хүүхдийн 13 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

33	Дотоод албан томилолт	78,000	78,000	-	100.00
34	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,364,100	1,364,100	-	100.00
35	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,264,100	1,264,100	-	100.00
36	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000	100,000	-	100.00
37	Бараа үйлчилгээний бусад зардал	1,009,400	1,009,400	-	100.00
38	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,009,400	1,009,400	-	100.00
39	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	150,000	150,000	-	100.00
40	Бусад урсгал шилжүүлэг	150,000	150,000	-	100.00
41	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	150,000	150,000	-	100.00
42	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	295,086,500	282,020,979	13,065,521.00	95.57
43	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	268,132,800	256,458,099	11,674,701.00	95.65
44	Улсын төсвөөс санхүүжих			-	
45	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	268,132,800	256,458,099	11,674,701.00	95.65
46	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	26,953,700	25,562,880	1,390,820.00	94.84
47	Орон нутгийн төсвөөс	26,953,700	25,562,880	1,390,820.00	94.84
48	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.00
49	Төсвийн байгууллага	1	1	-	100.00
50	АЖИЛЛАГСАДЫН ТОО	20	20	-	100.00
51	Удирдах ажилтан	1	1	-	100.00
52	Гүйцэтгэх ажилтан	8	8	-	100.00
53	Үйлчлэх ажилтан	11	11	-	100.00
54	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	120	120	-	100.00
55	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	120	120	-	100.00
56	Төрийн өмчит СӨБ байгууллага	120	120	-	100.00
57	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	20	20	-	100.00
58	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	11	11	-	100.00
59	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9	9	-	100.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөг /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	191,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	191,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	191,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	140,000.00
210401	Бичиг хэрэг	140,000.00
2105	Нормативт зардал	51,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	51,900.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	191,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	191,900.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	191,900.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Эрдэнэбулган сумын Хүүхдийн 13 дугаар цэцэрлэг нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Цог-Эрдэнэ гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэбулган сумын Хүүхдийн 13 дугаар цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24 -ны өдрийн 06 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Эрдэнэбулган сумын Хүүхдийн 13 дугаар цэцэрлэг нь Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д “бие бялдрын хувьд эрүүл чийрэг өсгөж хөгжүүлэх, ариун цэвэр, эрүүл ахуйн зөв дадал, хэвшилтэй болгох”, 5.1.2-д “хэл яриа, сэтгэхүйн чадвар эзэмшүүлэх, хүрээлэн байгаа орчин, юмс үзэгдлийн талаар анхны мэдэгдэхүүнтэй болгох”, 5.1.3-д “хүүхдийн гоо зүйн мэдрэмжийг хөгжүүлэн дүрслэн зурах, урлан бүтээх, дуулж хөгжимдөх, бүжиглэх чадвар эзэмшихэд туслах”, 5.1.4-д “хүүхэд өөрийгөө зөв илэрхийлэх, бусдыг хүндэтгэн харилцах, харилцааны хэлбэрээс хүчирхийллийг ялгаж, мэдээлэх чадвартай болох, ардын ёс заншлыг танин мэдэхэд нь туслах” гэж заасны дагуу харьяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулдаг, БШУЯ-ны харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд *“Хүүхдийн сурах үйлийг дэмжиж, хүүхэд бүрийн тэгш хамран сургахад бүх талын оролцоо хамтын үйл ажиллагааг өргөжүүлж тэдний хөгжил төлөвшил сурлагын амжилт чанарта ахиц гаргах багш бүр ээлжит хичээлийн бэлтгэлийг чанартай ханган сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх багш мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх”* гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын нэгжтэй ба байгууллагын болон санхүүгийн үйл ажиллагаанд 8 чиглэлээр хяналт шалгалтыг хийж шалгалтаар илэрсэн зөрчилд үүрэг даалгавар өгч зөрчлийг арилгуулж ажилласан тул үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, аудитын албанаас төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэбулган сумын Хүүхдийн 13 дугаар цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 295.0 сая төгрөгөөс 1 хувиар буюу 2.95 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 2.0 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 5.4 сая төгрөгөөр буюу 0.6 хувиар өсч материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	/сая.төгрөгөөр/
				Хувь
Бараа материал	31.57	44.69	13.12	141.6
Үндсэн хөрөнгө	861.32	853.64	(7.69)	99.1
<b>Нийт хөрөнгө</b>	892.89	898.32	5.43	100.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	892.89	898.32	5.43	100.6
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	892.89	898.32	5.43	100.6

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материалын үлдэгдэл 41.6 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 31.6 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 21.9 сая төгрөг, үндсэн хөрөнгийн шинжгүй хөрөнгийг бараа материалруу шилжүүлэн авсан 8.9 сая төгрөгийн нийт 30.8 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 17.7 сая төгрөгийн зарцуулалт гарч, 44.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 0.9 хувиар буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 861.3 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 2.2 сая төгрөг, үлдэгдэл өртөггүй хөрөнгийг данс бүртгэлээс хасч дахин үнэлж шинээр бүртгэсэнтэй холбоотойгоор 8.7 сая төгрөг нийт 12.1 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 19.8 сая төгрөгийн элэгдлээр буурч оны эцэст 853.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүн 5.4 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой.

## Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/ сая.төгрөгөөр/		
	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт -/орон нутгийн төсөв/	25.82	26.95	1.13
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт -/улсын төсөв/	252.76	268.13	15.37
Нэмэлт санхүүжилтийн орлого	0.11	0.19	0.09
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	9.96	-
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	9.85	8.93	(0.92)
<b>Үйл ажиллагааны орлого</b>	<b>288.54</b>	<b>314.17</b>	25.63
Цалин, шимтгэлийн зардал	227.41	233.37	5.95
Бусад бараа үйлчилгээний зардал	63.10	62.15	(0.95)
Урсгал шилжүүлэг	6.19	13.22	7.03
<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>296.70</b>	<b>308.73</b>	12.03
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(8.16)</b>	<b>5.43</b>	13.60

Эрдэнэбулган сумын Хүүхдийн 13 дугаар цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 16.4 сая төгрөгөөр буюу 5.9 хувиар өссөн нь тогтмол зардал нэмэгдсэнтэй холбоотой байна. Төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зардлыг 373.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 78.2 сая төгрөгөөр бууруулж, зардлыг 295.0 сая төгрөгөөр хянаж баталсан байна. Харин тайлант онд батлагдсан төсвийн дүнг 4.6 хувиар буюу 20.4 сая төгрөгөөр бууруулан тодотгожээ. Төсөв бууруулсан шалтгаан нь ковид 19 цар тахал холбоотойгоор хүүхдийн хоолны зардал хэмнэгдэж төвлөрүүлсэнтэй холбоотойгоор буурсан байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагч 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 295.0 сая төгрөгийн төсөв батлагдсан. Гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн авч, 282.0 сая төгрөгийг зарцуулж, 13.0 сая төгрөгийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлж, тайлант онд батлагдсан төсвийг 4.4%-иар хэмнэж төсвийн хэмнэлтийг бий болгосон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн БШУГ-аас 0.05 сая төгрөгийн орлого санхүүжилт олгосон ба ковид19 цар тахалтай холбоотойгоор цэцэрлэгийн байр болон гадна талбайг ариутгал халдваргүйтгэл хийлгэхэд, тендерийн баримт бичиг худалдан авсан 0.14 сая төгрөгийн орлогыг бичиг хэргийн зардалд тус тус зарцуулсан байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Боловсролын тухай хуульд 2021 оны 07 дугаар сарын 02, 11 дүгээр сарын 12, 12 дугаар сарын 17-ны байдлаар 3 удаа нэмэлт өөрчлөлт орсон байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд 51 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 92 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 295.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 95.6 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд орон тоо нэмэгдүүлээгүй, шагнал урамшуулал олгоогүй, автомашин худалдан аваагүй байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээллэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Эрдэнэбулган сумын Хүүхдийн 13 дугаар цэцэрлэг нь 2021 онд нийт 642.0 сая төгрөгийн 145 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 642.0 сая төгрөгийн 145 мэдээллийг хугацаанд нь ил тод байршуулсан байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

1. Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 27.4% буюу 8.9 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгосон байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт нь холбогдох шалгуурт тус тус нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан эсэхийг шалгах нь зүйтэй байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

Санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчилтэй асуудал илрээгүй болно.

-----oOo-----

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс								
					Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал													
1													
Дүн													
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал													
Дүн													
<b>Нийт дүн</b>													